

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР УРИЛГА

2026.03.23

Улаанбаатар хот

Үнийн санал ирүүлэх тухай

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу ЗГХХГ/20260602035 тендер шалгаруулалтын кодтой, 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсөвт өртөгтэй “Хуулийн нийцэл шалгах, бодлого, стратегийн баримт бичгүүдэд хэрэгжилтийн эрсдэлийн түвшинг тооцоолох, хийдэлтэй үйл ажиллагааны дарааллыг тогтоох, хиймэл оюунд суурилсан шинжилгээ хийх” барааг шууд худалдан авалтаар сонгон шалгаруулах үнийн санал хүлээн авах урилгыг хүргүүлж байна.

Нийлүүлэгч байгууллага нь Захиалагчийн баталсан Ажлын даалгаврын дагуу нийлүүлэх барааны үнийн санал, техникийн тодорхойлолт болон бусад холбогдох баримтын хамт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10:00 цаг хүртэл ts.iderbat@ags.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Шаардлагатай мэдээллийг 51-262014 дугаарын утсаар тодруулж болно.

Ажлын даалгаврыг хавсаргав.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Улаанбаатар-15160 Утас: 51-262041

Үнэлгээний хороо



**ХУУЛИЙН НИЙЦЭЛ ШАЛГАХ, БОДЛОГО, СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД
ХЭРЭГЖИЛТИЙН ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ ТООЦООЛОХ, ХИЙДЭЛТЭЙ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДАРААЛЛЫГ ТОГТООХ, ХИЙМЭЛ ОЮУНД СУУРИЛСАН
ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

№	Нэр төрөл	Тайлбар
1	Зорилго	Хуулийн нийцэл шалгах, хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хэрэгжилтийн эрсдэлийн түвшинг тооцоолох, хийдэлтэй үйл ажиллагааны дарааллыг тогтооход дэвшилтэт технологи ашиглан хиймэл оюунд суурилсан шинжилгээ хийхэд оршино.
2	Захиалагч байгууллага	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
3	Системийн Функциональ шаардлага	<p>Систем нь дараах үндсэн модулиуд болон боломжуудыг заавал агуулсан байна. Үүнд:</p> <p>3.1. AI Комплаенс болон Гар шинжилгээний модуль:</p> <ul style="list-style-type: none"> • Framework үүсгэх: Аливаа хууль, тогтоомж, стандартын баримт бичгийг (pdf, excel, word зэрэг форматтай) системд оруулахад AI автоматаар уншиж, зүйл заалт бүрээр нь салгаж "Шалгуур үзүүлэлтийн жагсаалт" үүсгэдэг байх. Мөн хэрэглэгч үүнийг гар аргаар засах, баталгаажуулах боломжтой байх. • Нийцлийн шинжилгээ: Төрийн байгууллагуудын ирүүлсэн тайлан, төлөвлөгөө, батлагдсан журам, нотлох баримтуудыг тухайн шалгуур үзүүлэлттэй тулгаж, AI-ийн тусламжтайгаар харьцуулан шинжилдэг байх. • Үр дүн ба тайлагнал: Шалгуур бүрийг хангасан эсэхийг үнэлж (хангасан/хангалтгүй/хэсэгчлэн хангасан), шалтгааны тайлбарын хамт гаргах. Нийт хэрэгжилтийн хувийг бодож, хяналтын дашбоард дээр харуулах. <p>3.2. Процесс, үйл ажиллагааны удирдлагын модуль:</p> <ul style="list-style-type: none"> • Дүрэм, журмын дагуу үйл ажиллагааны дараалал, процессыг хэрэглэгч өөрөө угсрах боломжтой байх. • Хийдэлтэй үйл ажиллагааны дарааллыг тогтоож, процессыг оновчтой болгох. • Үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулах. <p>3.3. Хиймэл оюуны нэмэлт хэрэгслүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Баримт бичгийн харьцуулалт: Хоёр түүнээс дээш тооны эрх зүйн баримт бичгийн найруулгыг хооронд нь харьцуулж,

		<p>өөрчлөлт, агуулгын зөрүүтэй байдлыг илрүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> • Эрх зүйн актын чанарын үнэлгээ: Боловсруулсан дүрэм, журмын төслийн найруулга, хууль зүйн техникийн шаардлага хангасан байдлыг AI-аар үнэлүүлэх. • AI Chatbot (Туслах): Системд орсон хууль, стандартуудын хүрээнд хэрэглэгчдийн асуусан асуултад үнэн зөв, хуулийн зүйл заалтаас иш татан хариулж, тайлбарлах чадвартай хиймэл оюуны туслахтай байх. • Драфт үүсгэх: Өгөгдсөн шаардлагын дагуу дүрэм, журмын анхны ноорог (draft) боловсруулах.
4	Системийн техникийн боломж, аюулгүй байдлын шаардлага	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн аюулгүй байдал: Систем нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001 стандартын шаардлагыг хангасан байх. • Чанарын баталгаа: Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартын гэрчилгээтэй байх. • LLM Технологийн түншлэл: Дэлхийн тэргүүлэх хиймэл оюун хөгжүүлэгч (Google, OpenAI, Microsoft зэрэг) Enterprise түвшний API ашиглах албан ёсны эрхтэй байх. • Хандалтын эрхийн удирдлага: Хэрэглэгчдийн эрхийг нарийвчлан тохируулах (Role-based access control), системд хийгдсэн бүх үйлдлийн түүхийг хадгалах (Activity Log / Audit trail) боломжтой байх. • Оюуны өмч: Санал болгож буй платформ, системийн шийдлийн оюуны өмчийн эрхтэй байх.
5	Гүйцэтгэгчид тавигдах туршлагын шаардлага	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологи, хиймэл оюуны чиглэлээр тасралтгүй 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх. • Зах зээлд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан, хүлээн зөвшөөрөгдсөн байх. • Байгууллагын процессийн инженеринг, комплаенс, хууль эрх зүйн баримт бичгийн хиймэл оюуны шинжилгээний чиглэлээр бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан байх.
6	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Системийн нэвтрүүлэлт: ЗГХХГ-ын онцлогт тохируулсан системийн хандах эрхүүд (админ, шинжээч, удирдлага, энгийн хэрэглэгч гэх мэт) болон платформын ашиглалтын эрх. • Өгөгдөл оруулах, сургах: Шаардлагатай хууль, тогтоомжуудыг системд оруулж, AI загварыг байгууллагын онцлогт тохируулах. • Гарын авлага ба сургалт: Системийг ашиглах хэрэглэгчийн гарын авлага, видео заавар болон ЗГХХГ-ын нийт холбогдох албан хаагчдад зориулсан 2-оос доошгүй удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулах. • Техникийн дэмжлэг: Гэрээт хугацааны туршид системийн хэвийн ажиллагаа, найдвартай байдлыг хангах, засвар үйлчилгээ үзүүлэх.

ХЯНАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА



Б.БИЛЭГДЭМБЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СИСТЕМИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ



Ц.НАРАНЧИМЭГ